



Зөв
Хүндэтгэл
Газар

ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

ЭЛСЭЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

МОНГОЛ ХЭЛ Онлайн сорил-4

4 сарын 26 14.00-15.20

ТАЛ

Найр өндөрлөх шиг талын нар жаргах нь хүртэл сайхан. Нар жаргасан хойно тэнгэрийн хаяанд гүүн зэлний тоос адил улаан туяа удтал татан байна. Дараа нь цагаан гэгээ тасарна. Цагаан гэгээ тасрахад холын бараа бас тасарна. Тэнгэрт үдшийн гялаан цайрч, сая нийлсэн саах малын чимээ намжирч, ингэ саах завсар шар гэгээ татна. Шар гэгээ тасарч, бор гэгээ татах үед ойрын юм бүрэлзэн, харанхуй гэрт тогоотой сүү саран мэт мэлтийнэ. Саах ялгаж хонь хотолсон хойно бор гэгээ тасарч, сая харанхуй шөнө болно. Тэнгэрийн од бүрэн түгэхэд адуу бэлчсэн зүгт хүртэл одод гялалзана. Манайхан явуулын хүн тухлан дайлж, газар холын сонин сонсохоо жаргал гэж үздэг болоод ч тэр үү, харанхуй шөнө алсын чимээ авмагц хүн төөрөх вий гэж гаднаа гал гарган, ирэн иртэл нь гаднаа зогсоно. Сураагүй хүн шөнийн талд төөрнө гэдэг амархан. Харагдахаас одод, сонсогдохоос шөнийн салхи. Нохойн дуу сонсох санаатай хаа нэгхэн хашхирч, жолоо татан, чимээ чагнаж явахад гэнэт тэнгэрийн хаяан дахь оддын дунд галын бараа харагдана. Тэр зүгт зөндөө давхиж байж сая нохойн дуу дуулдаж, аргалын утаа үнэртэн, сэтгэлийн дотор баяр гийнэ. Аав дээл нөмрөн тамхи татаж, галын бадамлан бадрах дөлийг ширтэн суудаг сан. Хөлгүй их устай газрынхан усныхаа үрсгалыг ширтэн сууж алжаалаа тайлдаг гэсэн, **манайхан өдрийн цагт талаа харж, үдшийн цагт галаа харж алжаалаа тайлж, орчлон хорвоогийн амьдралыг арвантаа эргэцүүлэн бодно. Ерөөс тэнгэрийн царай, салхины аяс, ногооны гарц, малын араншингаар эргэх дөрвөн цагт малаа адуулдаг болоод унтахын өмнө заавал гаднаа гарч, тэнгэрийн царай харж унтана. Талд өглөө сар хүртэл чөдөртэй морь шиг ойрхон хоносон байна. Өглөөний нар уртын дуу эхлэх шиг мандана.** Аянга цахилгаан, алтан нар цөм талд бараатай ирдэг болоод нарнаас өмнө адуундаа хүрэх сайхан.

Манайхан угаас дуучин удамтай улс. Дуулахдаа ямар үйдсандаа дуулах биш дээ. Тэнгэр сайхан, мал бүрэн л бол хар аяндаа морин дэл дээр дуулна. Дуугаа зугуухан, дэргээд дэргээд, дээлийн хормой дэрвүүлэнхэн, дэрсэн толгой ганхууланхан эхэлнэ. Тэгснээ дээшлэн дээшилсээр, хурдны морь эргэх шиг чавхдан чавхдан, чавхдах газраа бараагүй чавхдан, цогин цогин, цогих газраа бөмбөлзтөл цогин, хатиран хатиран, хатирах газраа урсанхан хатирч, хулан тахь шиг хулжинхан алга болдог билээ.

Салхидсан хонь эргэчихээр эрчимтэйхэн дуулах түрүүчийн аяа нэхүүлэн улам улам алслуулж, нуур бидэрлэх мэт шуранхайлж, зуны нар жаргах адил дуусгана. Дууны аянд үд дундын бүгчим халуунд хорсон салхи сортолзон оройн сэрүү унах шиг болдог сон. Дуу бүхэн маань сэтгэлийн уудмаас гарна. Сэтгэлээ манайхан талаас авна. Тийм болохоор сэтгэл маань ув уужуу, түв тунгалаг. Дууныхаа аянд улам улам ариусаж байдаг билээ.

Д.Батбаяр

1.

Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | |
|-------------|---|
| 1. бидэрлэх | a. морь малын өмнөд ба хойд хоёр хөл зэргээр, ээлжлэн харайлан явах |
| 2. адуулах | b. юман дээр өөр өөр жижиг зурвас гарах |
| 3. хулжих | c. их халуунд хурж бөөгнөрөх |
| 4. цогих | d. мал, тэжээвэр амьтдыг маллах, хариулах |
| 5. хорох | e. амьтны айж жигшин зугтаж зайлах, буруулах |
- A. 1b, 2d, 3e, 4a, 5c B. 1d, 2c, 3a, 4b, 5e C. 1b, 2d, 3e, 4c, 5a
D. 1a, 2d, 3c, 4e, 5b E. 1b, 2d, 3a, 4e, 5c

2.

Талын хүн тусч, сайхан сэтгэлтэй болохыг батлах баримтыг олоорой.

- A. Тэр зүгт зөндөө давхиж байж сая нохойн дуу дуулдаж, аргалын утаа үнэртэн, сэтгэлийн дотор баяр гийнэ.
- B. Манайхан явуулын хүн тухлан дайлж, газар холын сонин сонсохоо жаргал гэж үздэг.
- C. Харанхуй шөнө алсын чимээ авмагц хүн төөрөх вий гэж гаднаа гал гарган, ирэн иртэл нь гаднаа зогсоно.
- D. Аав дээл нөмрөн тамхи татаж, галын бадамлан бадрах дөлийг ширтэн суудаг сан.
- E. Манайхан өдрийн цагт талаа харж, үдшийн цагт галаа харж алжаалаа тайлж, орчлон хорвоогийн амьдралыг арвантаа эргэцүүлэн бодно.

3.

. Талынхан дуугаа зугуухан, дэргээд дэргээд дээлийн хормой дэрвүүлэнхэн, дэрсэн толгой ганхууланхан дуулж эхэлдгийн учир юу вэ?

- A. Өглөөний нар уртын дуу эхлэх шиг мандана.
- B. Тэнгэр сайхан, мал бүрэн л бол хар аяндаа морин дэл дээр дуулна.
- C. Усныхаа урсгалыг ширтэн алжаалаа тайлах гэж дуулдаг.
- D. Дуу бүхэн маань сэтгэлийн уудмаас гарна.
- E. Уйдсан учраас ардын дуу дуулдаг.

4.

. Эхийн сэдвийг олоорой.

- A. Хүлэг морьдын тухай
- B. Уртын дууны тухай
- C. Талын нарны тухай
- D. Тал нутгийн тухай
- E. Аянга цахилгааны тухай

5.

. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой.

- A. Талд өглөө сар хүртэл чөдөртэй морь шиг ойрхон хоносон байна.
- B. Найр өндөрлөх шиг талын нар жаргах нь хүртэл сайхан.
- C. Манайхан өдрийн цагт талаа харж, үдшийн цагт галаа харж алжаалаа тайлдаг.
- D. Аянга цахилгаан, алтан нар цөм талд бараатай ирдэг болоод нарнаас өмнө адуундаа хүрэх сайхан.
- E. Сэтгэлээ манайхан талаас авна. Тийм болохоор сэтгэл маань ув уужуу, тув тунгалаг.

6.

“Манайхан угаас дуучин удамтай улс” - Зохиогчийн ямар хандлага, өнгө аяс илэрч байна вэ?

- A. бахархан бахадсан
- B. бишрэн магтсан
- C. баярлаж хөөрсөн
- D. дурсан санагалзсан
- E. харуусаж халагласан

7. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг тодорхойлоорой.

- A. Талын тухай нэг сэдэвт нэгтгэн, учир зүйн дэс дараатай өгүүлсэн тул хүүрнэмж.
- B. Тал, талын малчны тухай мэдээлэл өгөх зорилгоор тоочсон тул тайлбарламж.
- C. Талын малчны тухай тайлбарлан таниулахдаа оюун дүгнэлтэд тулгуурласан тул эргэцүүлэмж.
- D. Тал, талын малчин хүний онцлог шинжийг нэгэн орон зайд дүрсэлсэн тул тоочимж.
- E. Талын хүний амьдралын онцлогийг тоочиж, дүгнэн бичсэн учир тайлбарламж, эргэцүүлэмж хосолсон хэв маяг.

8. “Талд өглөө сар хүртэл чөдөртэй морь шиг ойрхон хоносон байна” гэсэн хэсгийн зүйрлэх ур маягийн үүргийг тодорхойлно уу.

- A. Сар талд хонодог гэсэн санааг илэрхийлсэн.
- B. Талын саран ойрхон хонодог гэсэн санааг илэрхийлсэн.
- C. Талд бүх юм нүдэнд ил, ойрхон харагддаг гэсэн санааг илэрхийлсэн.
- D. Талд өглөө сар хүртэл ойртсон байдаг гэсэн санааг дүрсэлсэн.
- E. Талын сар, чөдөртэй морь хоёр адилхан гэдгийг харуулсан.

9. “өдрийн од шиг” гэсэн хэлцийн ойролцоо утгатайг нь сонгоорой.

- A. ус цас шиг
- B. нүдний гэм
- C. талаар нэг
- D. газраар нэг
- E. нуур далай шиг

10. “Өдрийн цагт талаа харж, үдшийн цагт галаа харж алжаалаа тайлдаг” гэсэн өгүүлбэрийг тонгоргож хувиргасан нь аль вэ?

- A. Өдрийн цагт талаа харж, бүрэнхий үдшийн цагт галаа харж, алжаал ядаргаагаа тайлдаг.
- B. Үдшийн цагт галаа харж, өдрийн цагт талаа харж алжаалаа тайлдаг.
- C. Үдшийн цагт галаа харж, алжаал ядаргаагаа тайлдаг.
- D. Өдрийн цагт талаа хараад, үдшийн цагт галаа хараад алжаалаа тайлдаг.
- E. Өдрийн цагт талаа ширтэн, үдшийн цагт галаа ажиг, алжаалаа тайлдаг.

11. Онцолсон үгийг ойролцоо утгатай үгээр солин найруулбал аль үг нь оновчтой вэ?
“Өглөөний нар уртын дуу эхлэх шиг **мандана**...”
A. дээшлэх B. гарах C. хөөрөх D. бадрах E. жаргах
12. “Тэнгэр сайхан, мал бүрэн л бол хар аяндаа **морин** дэл дээр дуулна” – Онцолсон үгийг дээд найруулгаар бичсэн нь аль вэ?
A. үрээ B. адуу C. хүлэг D. адасга E. азарга
13. “Хүн төөрөх **вий** гэж гаднаа гал гарган, ирэн иртэл нь гаднаа зогсоно”- Онцолсон бүтээврийн баймж утгыг тодорхойлоорой.
A. хориглох B. үгүйсгэх C. сануулан хориглох
D. тааварлан барагцаалах E. магадлан онцлох
14. “Аянга цахилгаан, алтан нар цөм **талд** бараатай ирдэг болоод нарнаас өмнө адуундаа хүрэх сайхан”- Өгүүлбэрт онцолсон гишүүний утга, үүргийг тодорхойлно уу.
A. “ирдэг” гэсэн үйл үгийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
B. “аянга” гэсэн жинхэнэ нэрийг зорилгын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
C. “хүрэх” гэсэн үйл үгийг цагийн утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
D. “болоод” гэсэн үйл үгийг шалтгааны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
E. “сайхан” гэсэн тэмдэг нэрийг цагийн утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
15. Үйлийн өнгөрсөн цагаар тодотгон холбох нөхцөлөөр хувилсан үгийг олоорой.
A. нөмөрсөн B. болж C. бадамлан D. ширтсээр E. суудаг сан

16.

Өгүүлбэрт хашилт хэрэглэсний учир юу вэ?

... Манж ноён аль хэдийн өрөөсөн сахалтай болчихоод, “Хай, энэ яасан их галтай” гэж толгой сэгсэрч суусан юм гэдэг.

- A. Сэтгэл ихэд хөдлөн хэлсэн буюу уриалсан, анхааруулсан өгүүлбэрийг хашилтад бичнэ.
- B. Аливаа үгийг ерийн утгаар биш, онцлон заасан буюу өгөөдсөн утгаар хэрэглэвэл хашилтад хийнэ.
- C. Өгүүлбэрийн дотор тайлбар, тодорхойлолт, нэмэлт ажиглалт зэрэг үг өгүүлбэрийг хашилтад хийнэ.
- D. Ном зохиол, албан байгууллага зэргийн оноосон нэрийг их төлөв хашилтад бичнэ.
- E. Шууд хэлсэн хөндлөнгийн үг, өгүүлбэрийг хашилтад хийнэ.

17.

Төрөл бус утгат үгийг олоорой.

- A. олз
- B. олговор
- C. олдвор
- D. олдоц
- E. олс

18.

Албан бичгийн найруулгад тохирох үгийг сонгоно уу.

- A. хөгшин аав
- B. өвөө
- C. буурай
- D. өвөг эцэг
- E. ажаа

19.

Нутгийн аялгууны үгийг халх аялгуунд зөв буулгасан нь аль вэ?

Та аль нутгаан тохонтаа күмэн билээт?

- A. Та аль нутгийн тохонт хөвүүн билээ?
- B. Та аль нутгийн тохонтой хүн билээ?
- C. Та аль нутгаар тохонтой билээ?
- D. Та аль нутагт төрсөн хүн билээ?
- E. Та аль нутагт төрсөн хүн билээ?

20.

Найрч угсарсан нийлмэл үгийг сонгоно уу.

- A. Алтан нар
- B. Нохойн дуу
- C. Үдшийн гялаан
- D. Аянга цахилгаан
- E. Салхины аяс

21.

Утгыг зөв харгалзуулсныг олно уу.

- | | |
|----------|-----------------------|
| 1. даах | a. хүүхдийн нялхын үс |
| 2. дайх | b. өргөж дийлэх |
| 3. даахь | c. бусдаар дамжуулах |

- | | | |
|---------------|---------------|---------------|
| A. 1b, 2a, 3c | B. 1a, 2c, 3b | C. 1c, 2a, 3b |
| D. 1a, 2b, 3c | E. 1b, 2c, 3a | |

22.

Үгийн үндэс (язгуур) -д залгавар залгахад зөөлний тэмдэг “и” болсон үгсийг олоорой.

- | | |
|------------------------------|------------------------------|
| A. захиалсан, бариулж, хориг | B. ашиг, хачин, шашин |
| C. горхиноос, танил, сахисан | D. халим, торниж, хийморьгүй |
| E. саальчин, зорилго, ашиг | |

23.

“нэг + д + гэ + чих + ээд” гэсэн бүтээврийн нийлцийг зөв бичсэн нь аль вэ?

- | | | |
|-----------------|----------------|-----------------|
| A. нэгдгэчихээд | B. нэгдгэчхээд | C. нэгтгэчихээд |
| D. нэгтгэчхээд | E. нэгтэгчхээд | |

24.

“Солонгос хүүхдийн гутлын дэлгүүрт шинэ бараа ирлээ” гэсэн өгүүлбэрийн найруулгын алдааг зөв зассаныг олоорой.

- A. Хүүхдийн гутлын солонгос дэлгүүрт шинэ бараа ирлээ.
- B. Хүүхдийн гутлын дэлгүүрт шинэ бараа ирлээ.
- C. Хүүхдийн солонгос гутлын дэлгүүрт шинэ бараа ирлээ.
- D. Солонгосын хүүхдийн гутлын дэлгүүрт шинэ бараа ирлээ.
- E. Солонгосоос ирсэн хүүхдийн гутлын дэлгүүрт шинэ бараа ирлээ.

25.

5. Я.Кавабата “Ангийн даргын мөрдлөг” зохиол дахь Фүмиогийн хэлсэн үгээс зан төрхийг нь тодорхойлно уу.

“...Сэйчи хэчнээн сурч мэдэхийг хүсэж байгаа ч гэлээ яагаад ийм юм хийж байгаа юм бол оо? Би ингэж цорын ганц найзаа сэжиглэж болно гэж үү? Гэхдээ ангийн даргын хувьд, ангийнхныхаа төлөө хардахгүй байж болохгүй нь...”

- | | | |
|-----------------------|-----------------------|--------------------|
| A. нөхөрсөг, өрөвч | B. зарчимч, хүнлэг | C. ажилч хичээнгүй |
| D. нийтэч, хамт олонч | E. бялдууч, их зантай | |

26.

1. П.Лувсанцэрэн “Усны эргүүлэг ба Борзооны явдал” туужийн дараах хэсэгт ямар хам сэдэв хөндөгдөж байна вэ?

“Манай сургууль энэ намар нэг хэсэгтээ тэр бохир эргүүлэгт орчихсон юм шиг өлсгөлөн, хулгай зэлгий, өвчин зовлонтой хутгалдаж бужигналаа. ...Дайн дуусаж, сургууль, эмнэлэг, юм бүхэн тохижиж, тэр булингартай эргүүлгээс бүрмөсөн гарах цаг мөдхөн ирнэ...”

- A. шашны B. түүхийн C. соёлын D. улс төрийн E. нийгмийн

27.

1. Альфонс Доде “Сүүлчийн хичээл” өгүүллэгийн дараах хэсгээс дотоод орчныг тодорхойлно уу.

“... Хүн бүр л чив чимээгүй байхыг хичээж байсан сан. Цаасан дээр үзэг чахрахаас өөр дуу огт гараагүй. Анги дотор хаврын цох нисэж байгааг ч мэдэхгүй. Бүгд л жаахан хүүхдүүд ч гэсэн бийрээ чамбайхан барьчхаад хичээнгүйлэн бичиж байгаа нь аргагүй л франц хэлний хичээл ажгуу”

- A. Хаврын цох нисэж байгааг ч мэдэхгүй дүнсгэр орчин.
B. Нам гүм, анир чимээгүй ноёлсон орчин.
C. Үзэг чахрахаас өөр аниргүй хүйтэн хөндий орчин.
D. Хичээлдээ шамдаж, шимтсэн дотно дулаан орчин.
E. Франц хэлний хичээлдээ шамдаж баярласан чимээгүй орчин.

28.

1. С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгт Төгөө өвгөн өөртөө “Ангаа өвгөн ингээд явчихдаг байж... Нутгийн нуруутай хэдэн өвгөний нэг байлаа даа...” гэж өгүүлснээ маанийн шад уншихдаа ийш тийш сэлбэлзэн харсны учир юу вэ?

- A. Тухайн нийгэм цаг үеийн байдлаас болж маань уншиж байгааг хүн харчих вий хэмээн болгоомжилсон.
B. Маань уншиж байгааг хүн харчих вий гэж санаа зовон ийш тийш сэлбэлзсэн.
C. Маанийн шад бувтнан уншихаасаа ичиж, ийш тийш сэлбэлзэн харсан.
D. Ангаа өвгөн бурхан болсон учраас монгол ёсоор маань мэгзэм уншсан.
E. Жаран нэгнийхээ жилийг ардаа хийсэн налайж суух насны хүн учраас хаширлан болгоомжилсон.

29.

. С.Дашдооровын “Бууж мордох хорвоо” өгүүллэгт бурхан болоочийн эцсийн замд халуун хошуутай мал байлгаж, “Хэн намайг тийн хичээснийг минь мэдэв л гэж. Мэдээд ч яах юм билээ. Бас мэдүүлээд ч яах билээ” хэмээсэн уужуу сэтгэлтэй монгол өвгөн хэн бэ?

A. Ангаа

B. Самбаа

C. Хангай

D. Төгөө

E. Сүрэн

30.

. Б.Явуухулан “Хар - Ус нуурын шагшуурга” шүлэгт “с”, “ш” авиаг түлхүү хэрэглэсний учир юу вэ?

Хар -Ус нуурын шагшуурга

Намрын салхинд исгэрнэ

Харахад нэг л уйтгартай

Намс намс бөхөлзөнө...

A. Хэлний уг, шүдний орноос төрдөг авиа тул исгэрэх, шуугих чимээг илэрхийлжээ.

B. Салхи, шагшуурга гэхэд орох авиа тул байгалийн чимээг чихэнд ойр, хөг аялгуутай болгож байна.

C. Салхины исгэрээ, зэгс шагшуурганы салхинд найгах чимээг дүрслэхийн тулд шуугиант, шүргэх гийгүүлэгч ашигласан.

D. Хар -Ус, салхи, шагшуурга гэхэд эдгээр авиа нь давтагдаж орсон байна.

E. Хар-Ус нуур шагшуургатай гэсэн санааг илэрхийлэхэд “с”, “ш” авиа хэрэглэгдэж байна.

31.

. Уншаад, зөв хөрвүүлснийг олоорой.

مەھسەر ٤ تەحنن مەنھەر
 مەھسەر مەنھەر ..
 مەھسەر مەنھەر تەحنن مەنھەر
 مەھسەر مەنھەر ..

- A. Утга чанар оновоос эрдэм юун.
Олз бодон гайхуулагч бардам бас юун .
- B. Утга чанар оновоос эрдэм юун буй.
Олз бодон гайхуулагч бардам бус юун буй.
- C. Утга чанар унаваас эрдэм юун буй.
Олз бодон гайхуулагч бардам бус юун буй.
- D. Утга чанар унаваас эрдэм юун буй.
Олз бодон гайхуулан бардам бас юун буй.
- E. Одоо чанар оновоос эрдэм юун буй.
Олз бодон гайхагч бардам бус юун буй

32.

. Уншаад, тохирох тайлбарыг сонгоорой.

مەھسەر مەنھەر
 مەھسەر مەنھەر
 مەھسەر مەنھەر

- A. юм мэдэхгүй байх
- B. бага зэргийн олз олох
- C. их сонин дуулах
- D. тэнгэр шиг уудам байх
- E. сүр бадруулан хэтрүүлж ярих

33.

. “Уртын гол” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

A.

مەھسەر مەنھەر

B.

مەھسەر مەنھەر

C.

مەھسەر مەنھەر

D.

مەھسەر مەنھەر

E.

مەھسەر مەنھەر

34.

4. Галигийг зөв бичсэн хэсгийг сонгоно уу.
Дагуу бүхүн сэдхил-үн агудам-ача гарун-а.

A.

مستوف وهلازم بهسراي صر
بستمكبر بكم نيتحمز ا ..

B.

مستوف وهلازم بهسراي صر
بستمكبر بكم نيتحمز ا ..

C.

مستوف وهلازم بهسراي صر
بستمكبر بكم نيتحمز ا ..

D.

مستوف وهلازم بهسراي صر
بستمكبر بكم نيتحمز ا ..

E.

مستوف وهلازم بهسراي صر
بستمكبر بكم نيتحمز ا ..

35.

. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

A.

زحمتو

B.

نزهتو

C.

محممتو

D.

نحيتو

E.

زحمتو

36.

. “талдаа” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

A.

تالدا

B.

تالدا و كق و كق و كق

C.

تالدا و كق و كق و كق

D.

تالدا و كق و كق و كق

E.

تالدا و كق و كق و كق

37.

. Бусдаар үйлдүүлэх хэвийн -га⁴ дагавартай үгийг олоорой.

A.

مخندكسين

B.

مخندكسين

C.

مخندكسين

D.

مخندكسين

E.

مخندكسين

38.

. “ир-” гэсэн үгийг цагаар төгсгөх нөхцөлөөр зөв хувилгасныг олоорой.

A.

مخندكسين

B.

مخندكسين

C.

مخندكسين

D.

مخندكسين

E.

مخندكسين

39.

. “шар үхэр, шар өнгө”-ийг утга ялгасан хэсгийг олоорой.

A.

مخندكسين
مخندكسين

B.

مخندكسين
مخندكسين

C.

مخندكسين
مخندكسين

D.

مخندكسين
مخندكسين

E.

مخندكسين
مخندكسين

40.

. “ диссертац” гэсэн үгийг зөв бичсэнийг олоорой.

A.

مخندكسين

B.

مخندكسين

C.

مخندكسين

D.

مخندكسين

E.

مخندكسين

2.1.

. Зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөрд зөвхөн нэг хариултыг будаарай)

- | | |
|------------------------------|---------------------|
| a. Сүү мэлтийнэ. | 1. цөм өгүүлбэр |
| b. Оддын дунд харагдана. | 2. цөм бус өгүүлбэр |
| c. Дууны нь аянд сортолзоно. | |
| d. Аргалын утаа үнэртэнэ. | |
| e. Аав галаа харна. | |

2.2.

. Монголын Нууц Товчоо дахь жишээг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулна уу.

- | | |
|--|--------------|
| a. Бөөр нь бөгсөнд
Цэр нь цээжинд байг | 1. ихэсгэл |
| b. Хавиргаа хазах хар нохой мэт
Хаданд довтлох харцага шонхор мэт | 2. юмшуулал |
| c. Гунжин үхрийг идэвч
Цадахгүй ходоодтой | 3. тойруулал |
| d. Харвах сумны халхавч болж
Хангинах зэвийн бамбай болох | 4. багасгал |
| e. Шүүдрээр унд хийж
Шүлсээр хоол хийх | 5. зүйрлэл |

2.3.

Зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөрд зөвхөн нэг хариултыг будаарай)

- | | |
|-------------------|---|
| a. өгүүлбэр + ээр | 1. Эгшигжүүлэх үүрэгтэй тул балархай эгшгийг гээхгүй. |
| b. тоног + ийг | 2. Балархай эгшиг үүрэггүй тул гээнэ. |
| c. дутагдал + аас | 3. Ялгах үүрэгтэй эгшгийг гээхгүй. |
| d. үзсэн + ээс | |
| e. жүжиг + ийн | |

2.4.

2.4. Үгсийг тохирох утгатай нь харгалзуулна уу. (a, b, c, d, e мөрд зөвхөн нэг хариултыг будаарай)

- | | | | | |
|---------------|------|------|------|------|
| a. Амь зуу- | 1. | 2. | 3. | 4. |
| b. Шүд зуу- | ᠰᠢᠳᠤ | ᠰᠢᠳᠤ | ᠰᠢᠳᠤ | ᠰᠢᠳᠤ |
| c. Эрдэнэ зуу | | | | |
| d. Зуу хоног | | | | |
| e. Зоо нуруу | | | | |

1	A		31	B
2	C		32	E
3	B		33	A
4	D		34	D
5	E		35	C
6	A		36	B
7	D		37	D
8	C		38	E
9	B		39	A
10	B		40	D
11	B		2.1	a1
12	C			b2
13	C			c2
14	A			d2
15	A			e1
16	E		2.2	a3
17	E			b5
18	D			c1
19	D			d2
20	C			e4
21	E		2.3	a1
22	A			b3
23	D			c2
24	C			d1
25	B			e2
26	E		2.4	a3
27	D			b1
28	A			c2
29	D			d1
30	C			e4